



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/14

Баян-Өндөр сум

Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.6, 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалын хоёр дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймгийн нутаг дэвсгэрт болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах үүрэг бүхий Гамшгаас хамгаалах албадыг нэгдүгээр, Гамшгаас хамгаалах албаны ажиллах нийтлэг журмыг хоёрдугаар, Ерөнхий болон Тусгай зориулалтын мэргэжлийн ангиудыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын хүч хэрэгслийн томилгоог сумын Засаг даргын захирамж, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга (захирал)-ын тушаалаар шийдвэрлэж, гүйцэтгэх үүргийг нь танилцуулж, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга (захирал) нарт үүрэг болгосугай.

3.Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, бүтэц зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг чиглэлийг тодорхойлж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатарт үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/560 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 09-ны өдрийн  
114 дугаар захирамжийн I хавсралт

### ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА

| №   | Гамшгаас хамгаалах албадын нэр                           | Түшиглэн байгуулах мэргэжлийн байгууллагууд /дэмжин ажиллах байгууллага/ | Тайлбар   |
|-----|--|--|---|
| 1.  | Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээлэх алба | Байгаль орчин, аялал жуулчлалын газар                                    | Түшиглэсэн байгууллагын дарга нь Орхон аймгийн гамшгаас хамгаалах албаны дарга бөгөөд тухайн салбарын хэмжээнд гамшгийн үеийн хариу арга хэмжээг төлөвлөж алба, мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажиллана. |
| 2.  | Барилга, хот байгуулалтын алба                           | Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ                       |   |
| 3.  | Зам, тээврийн алба                                       | Авто тээврийн төв  |   |
| 4.  | Уул уурхайн алба   | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ   |   |
| 5.  | Хүн ам, нийгмийн хамгаалалтын алба                       | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар                                   |   |
| 6.  | Хүнс, хөдөө аж ахуйн алба                                | Хүнс, хөдөө аж ахуйн газар   |   |
| 7.  | Эрчим хүч, дулаанаар хангах алба                         | Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК                                  |   |
| 8.  | Цахилгаан эрчим хүчээр хангах алба                       | Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК                             |   |
| 9.  | Ус хангамжийн алба                                       | Эрдэнэт-Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК                                    |   |
| 10. | Эрүүл мэндийн алба                                       | Эрүүл мэндийн газар  |   |
| 11. | Мэдээлэл, харилцаа холбооны алба                         | Орхон аймгийн Мэдээлэл холбоо, сүлжээ ТӨХК                               |   |
| 12. | Хэв журам сахиулах алба                                  | Цагдаагийн газар   |   |



Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 09-ны өдрийн  
А/14...дугаар захирамжийн II хавсралт

## ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАНЫ АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Орхон аймагт Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд гамшгаас хамгаалах алба (цаашид "Алба" гэх)-ны гүйцэтгэх нийтлэг чиг үүрэг, бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох, салбар хоорондын хамтын ажиллагааг хангахад энэ журмын зорилго оршино.

1.2. Төрийн захиргааны болон төрийн өмчит байгууллагыг түшиглэн аймгийн Засаг даргын захирамжаар албыг байгуулж, албаны даргыг томилно. Албаны дарга нь ЗДТГ-ын хэлтсийн дарга, төрийн захиргааны болон төрийн өмчит байгууллагын дарга байна.

1.3. Гамшгаас хамгаалах алба нь гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжлийн ангийг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус удирдлагын бүрэлдэхүүн (цаашид "штаб" гэх)-тэй байна.

1.4. Гамшгаас хамгаалах алба нь гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг тухайн салбарын мэргэжлийн ангиудыг удирдан зохион байгуулалтаар хангаж уялдуулан чиглүүлж ажиллана.

1.5. Гамшгаас хамгаалах алба нь Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, Аймгийн онцгой комиссоос чиглэл авч гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### Хоёр. Албаны эрх, үүрэг

2.1. Гамшгаас хамгаалах алба нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараах үүрэгтэй:

2.1.1. Гамшгаас хамгаалах албаны бүрэлдэхүүн, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

2.1.2. Шаардлагатай бол Онцгой байдлын газар, бусад албадтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, Онцгой комиссын даргаар батлуулах;

2.1.3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, үнэлгээнд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах;

2.1.4.Гамшгаас хамгаалах чиглэлээр захирамж, албан даалгавар, удирдамж гаргах, биелэлтийг шалгах, салбарын хүрээнд баримтлах дүрэм, журам, заавар боловсруулж батлах, хэрэгжүүлэх;

2.1.5.Аймгийн Засаг даргын Тамгын газар, Аймаг, сумын онцгой комисс, Онцгой байдлын газрыг мэргэжлийн зөвлөгөө, заавар, мэдээ мэдээллээр шуурхай хангах;

2.1.6.Гамшиг болон аюулт үзэгдэл, ослын үед салбарыг ажлын тусгай горимд шилжүүлэх, гамшгийн голомтын бүсэд мэргэжлийн анги, хүч хэрэгслийг шуурхай томилон ажиллуулах;

2.1.7.Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг шаардагдах техник, материал хэрэгслээр хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

Гурав. Штабын эрх, үүрэг

3.1.Штаб нь дараах эрх үүрэгтэй:

3.1.1.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, Онцгой байдлын газарт хянуулж Гамшгаас хамгаалах албаны даргаар батлуулах;

3.1.2.Гамшгаас хамгаалах албаны удирдлагын баримт бичгийг төлөвлөх, хүч хэрэгслийг томилж ажиллуулах;

3.1.3.Гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах тогтолцоог бүрдүүлж, дохиогоор ажиллах дадлага сургууль зохион байгуулах;

3.1.4.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бусад албанаас гаргуулан авч, мэдээллийн сан бүрдүүлэх;

3.1.5.Гамшиг, ослын нөхцөл байдлыг үнэлж, дүгнэн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.1.6.Сумдын гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтын бүсэд ажиллах;

3.1.7.Гамшгаас хамгаалах чиглэлээр мэргэжлийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж, сургалтын материал, гарын авлага боловсруулах;

3.1.8. Гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, улсын албаны шийдвэрийг Онцгой байдлын газар холбогдох гамшгаас хамгаалах алба, байгууллага, иргэдэд шуурхай хүргэх;

3.1.9.Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн, гамшгаас хамгаалах чиглэлээр албанаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг Онцгой байдлын байгууллагад хагас, бүтэн жилээр гаргаж хүргүүлэх.



## Дөрөв. Штабын бүрэлдэхүүн

4.1. Штаб нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

4.1.1. Штабын дарга-төрийн захиргааны төрийн өмчит байгууллагын дарга, орлогч, ерөнхий инженер албан тушаалтан;

4.1.2. Штабын орлогч-тухайн байгууллагын нэгжийн даргын томилсон албан тушаалтан;

4.1.3. Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан хаагч-тухайн төрийн захиргааны, төрийн өмчит байгууллагын гамшгаас хамгаалах асуудал хариуцсан /орон тооны/бус/ ажилтан;

4.1.4. Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан-тухайн байгууллагын мэдээлэл, холбооны асуудал хариуцсан албан тушаалтан;

4.1.5. Сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал хариуцсан ажилтан-тухайн байгууллагын сургалтын асуудал хариуцсан албан тушаалтан;

4.1.6. Санхүү, хангалт хариуцсан ажилтан-тухайн байгууллагын санхүү, хангалтын асуудал хариуцсан албан тушаалтан;

4.1.7. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан-тухайн төрийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан албан тушаалтан;

4.1.8. Бусад ажилтан-салбарын болон гамшгийн нөхцөл байдал (нөлөөлөл, хамрах хүрээ, цаг хугацаа, болзошгүй хохирол, үр дагавар)-ын онцлогоос шалтгаалан холбогдох албан тушаалтан, ажлын хэсгийг тухай бүр томилон ажиллуулж болно.

4.2. Штабын бүрэлдэхүүнийг тухайн салбарын бүтэц, зохион байгуулалттай нийцүүлэн өөрчилж болно.

4.3. Штабын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд нөхөн томилж, Онцгой байдлын байгууллагын холбогдох мэргэжилтэнд тухай бүр мэдэгдэнэ.

### Тав. Сургалт, дадлага

5.1. Албаны гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг Онцгой комиссын даргын баталсан хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулна.

5.2. Сургалт, дадлагыг дор дурдсан хугацаанд зохион байгуулна:

5.2.1. Албаны удирдах албан тушаалтан, штабын бүрэлдэхүүний сургалт, дадлагыг 2 жилд нэг удаа;

5.2.2. Мэргэжлийн ангийн сургалт, дадлагыг жил бүр;

5.2.3. Үүсч болзошгүй гамшгийн нөхцөл байдал, гамшгийн эрсдэл, давтамжийг харгалзан шаардлагатай сургалт, дадлагыг тухай бүр.

5.3. Албад хоорондын хамтарсан сургалт, дадлагыг албадын дарга нарын хамтарсан шийдвэрээр зохион байгуулна.

5.4.Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах албадын сургалт, дадлагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

5.5.Энэ журмын 5.2.1-т заасан сургалт, дадлагыг батлагдсан удирдамжийн хүрээнд Онцгой байдлын байгууллага, 5.2.2, 5.2.3-т заасан сургалт, дадлагыг тухайн гамшгаас хамгаалах алба, Онцгой байдлын байгууллага хамтран зохион байгуулах бөгөөд холбогдох зардлыг аймаг, сумын Онцгой комисс болон тухайн гамшгаас хамгаалах алба хариуцна.

#### Зургаа. Бусад

6.1.Гамшгаас хамгаалах албаны томилгоот албан хаагчдад гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр, идэвх санаачилгыг нь үнэлж тухайн салбарын болон Онцгой байдлын байгууллагын шагналаар шагнаж урамшуулж болно.

6.2.Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн албан хаагчийн албан томилолтын зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгоно.

6.3.Гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагааг Онцгой комиссын даргын баталсан удирдамжийн дагуу шалгаж, үнэлнэ.

Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 09-ны өдрийн  
... дугаар захирамжийн III хавсралт

### ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН АНГИ

| д/д | Хариуцах байгууллага                       | Мэргэжлийн ангийн хүний тоо |
|-----|--|-----------------------------|
| 1   | Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар | 66 хүн                      |
| 2   | Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар  | 66 хүн                      |

Тайлбар: Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги нь Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Мэргэжлийн ангийн дүрэм"-ийг мөрдөж ажиллана.

### ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН АНГИ

| № | Мэргэжлийн ангийн зориулалт                                | Бүлэг, хэсэг                             | Хариуцах байгууллага                            | Дэмжин ажиллах байгууллага                      |
|---|--|--|---|---|
| 1 | Байгалын болон цацраг химийн аюулыг үнэлэх мэргэжлийн анги | Байгалын болон химийн аюулыг үнэлэх үлэг | Ус цаг уур орчны шинжилгээний төв               | Байгал орчин аялал жуулчлалын газар             |
|   |  | Цацрагийн хяналтын бүлэг                 |   | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ                            |
| 2 | Хорогдох байрны мэргэжлийн анги                            | Хүлээн авах төлөвлөлтийн хэсэг           | Боловсрол шинжлэх ухааны газар                  | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар |
|   |  | Хангалтын хэсэг                          |   | Цэцэрлэгүүд                                     |
|   |  | Эрүүл мэндийн хэсэг                      |   | Өрхийн эрүүл мэндийн төвүүд                     |
|   |  | Нийгмийн хамгааллын хэсэг                |   | Ерөнхий боловсролын сургууль                    |
| 3 | Нүүлгэн шилжүүлэх мэргэжлийн анги                          | Аюулгүй байдлын хэсэг                    | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар | Зэвсэгт хүчний 186, 110 дугаар анги             |
| 4 | Тохижилт, үйлчилгээний мэргэжлийн анги                     | Ариун цэвэр халдвар хамгааллын хэсэг     | Хот тохижуулах газар                            | -   |
| 5 | Зам, гүүрний засвар үйлчилгээний мэргэжлийн анги           | Зам, гүүрний хэсэг                       | "Орхон АЗЗА" ТӨХК                               | -   |
|   |  | Механикжуулсан хэсэг                     |   | -   |
| 6 | Төмөр замын засвар, үйлчилгээний мэргэжлийн анги           | Төмөр замын засвар ашиглалтын бүлэг      | Эрдэнэт зангилаа                                | УБТЗ  |



|    |   |   |   |  |
|----|---|---|---|--|
| 7  | Инженер,<br>тэсэлгээний<br>мэргэжлийн анги                  | Тэсэлгээний ажлын<br>хэсэг  | Эрдэнэт үйлдвэр<br>ТӨҮГ                           | Зэвсэгт хүчний 186<br>дугаар анги          |
|    |   | Үйлчилгээний хэсэг  |   |  |
| 8  | Хүүхэд хамгааллын<br>мэргэжлийн анги                        | Хүүхэд хамгааллын<br>бүлгүүд  | Гэр бүл, хүүхэд,<br>залуучуудын<br>хөгжлийн газар | -  |
| 9  | Нийгмийн<br>хамгааллын<br>мэргэжлийн анги                   | Өндөр настан<br>хөгжлийн<br>бэрхшээлтэй иргэдийг<br>хамгаалах бүлэг | Хөдөлмөр,<br>халамжийн<br>үйлчилгээний газар      | -  |
|    |   | Сэтгэл зүйн дэмжлэг<br>үзүүлэх бүлэг                                | Нийгмийн эрүүл<br>мэндийн төв                     | -  |
| 10 | Хүнс хөдөө аж<br>ахуйн мэргэжлийн<br>анги                   | Ургамал, газар<br>тариалан хамгаалах<br>бүлэг                       | Хүнс хөдөө аж<br>ахуйн газар                      | Газар тариалан<br>эрхлэгч иргэд,<br>ААНБ   |
| 11 | Мал эмнэлгийн<br>мэргэжлийн анги                            | Мал эмнэлгийн<br>нарийн мэргэжлийн<br>бүлэг                         | Мал эмнэлгийн<br>газар                            | мал эмнэлгийн<br>нэгжүүд                   |
|    |   | Ариутгал<br>халдваргүйжүүлэлтийн<br>бүлэг                           |   | Онцгой байдлын<br>газар                    |
| 12 | Дулаан хангамжийн<br>мэргэжлийн                             | Дулааны шугамын<br>бүлэг  | Эрдэнэтийн ДЦС<br>ТӨХК                            | Эрдэнэт-Ус ДТС<br>ОНӨХК                    |
|    |   | Техникийн бүлэг   |   | -  |
|    |   | Хангалтын бүлэг   |   |  |
| 13 | Цахилгаан<br>хангамжийн<br>мэргэжлийн анги                  | Цахилгаан шугам<br>сүлжээний засварын<br>бүлэг                      | Эрдэнэт-Булганы<br>ЦТС ТӨХК                       | Эрдэнэт-Ус ДТС<br>ОНӨХК                    |
|    |   | Механикуулсан<br>хэсэг  |   | ЦДҮС ТӨХК-ийн<br>Хангай бүсийн<br>салбар   |
|    |   | Туршилт тохируулгын<br>хэсэг  |   |  |
| 14 | Ус хангамж,<br>хамгаалах<br>мэргэжлийн анги                 | Цэвэр, бохир усны<br>засварын бүлэг                                 | Эрдэнэт-Ус ДТС<br>ОНӨХК                           | -  |
|    |   | Уст цэг хамгаалах<br>бүлэг  |   | Дотоодын цэргийн<br>816-р тусгай<br>салбар |
| 15 | Эрүүл мэндийн<br>тусламж<br>үйлчилгээний<br>мэргэжлийн анги | Яаралтай тусламжийн<br>бүлэг  | Бүсийн оношилгоо<br>эмчилгээний төв               | Эрүүл мэндийн<br>газар                     |
|    |   | Хээрийн эмнэлэг   |   |  |
|    |   | Цус сэлбэх<br>хөдөлгөөнт бүлэг                                      |   |  |
|    |   | Эм эмнэлгийн<br>хэрэгслийн нөөц,<br>хангалтын бүлэг                 |   |  |
|    |   | Зоонозын өвчинтэй<br>тэмцэх бүлэг                                   |   | Мал эмнэлгийн<br>газар                     |



|    |  |  |  |   |
|----|--|--|--|---|
| 16 | Харилцаа холбоо, зарлан мэдээллийн мэргэжлийн анги     | Радио-телефон-үүрэн холбооны хэсэг     | <b>Орхон аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК</b>               | Үүрэн холбооны оператор ААНБ                              |
|    |  | Үйлчилгээ, засварын хэсэг              |  | Монголын цахилгаан холбоо ТӨХК Орхон салбар               |
|    |  | Зарлан мэдээллийн хэсэг                |  | Мэдээлэл шуурхай удирдлагын төв                           |
| 17 | Хэв журам сахиулах, ажиллагааны мэргэжлийн анги        | Хэв журам сахиулах бүлэг               | Цагдаагийн газар   | Тагнуулын газар   |
|    |  | Тусгай бүлэг                           |  |   |
| 18 | Санхүү нөөц, хангалтын мэргэжлийн анги                 | Санхүү, нөөц бүрдүүлэх бүлэг           | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс | Хүнсний зах, худалдааны төвүүд                            |
|    |  | Хүнсний хангалтын бүлэг                |  | Цэцэрлэгүүд   |
|    |  | Орон байр, хувцас хангалтын бүлэг      |  | Боловсролын газар   |
|    |  | Тээврийн бүлэг                         |  | Авто тээврийн төв   |
|    |  | Шатахуун, хийн түлш хангалтын бүлэг    |  | Шатахуун, хийн түлш импортлогч аж ахуйн гэж байгууллагууд |
| 19 | Иргэний бүртгэл мэдээлэл, статистикийн мэргэжлийн анги | Иргэний бүртгэл мэдээллийн бүлэг       | Улсын бүртгэлийн хэлтэс  | Статистикийн хэлтэс                                       |
|    |  | Статистик мэдээллийн бүлэг             |  |   |
| 20 | Хүмүүнлэгийн тусламж мэргэжлийн анги                   | Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг | Улаан загалмайн хороо  | Гаалийн газар   |
| 21 | Гал түймэр унтраах мэргэжлийн анги                     | Гал түймэр унтраах бүлэг               | Онцгой байдлын газар   | -   |
|    |  | Эрэн хайх, аврах бүлэг                 |  |   |
| 22 | Мэдээлэл сурталчилгааны мэргэжлийн анги                | Мэдээлэл сурталчилгааны бүлэг          | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн төв                | Орхон нутгийн Телевиз, ФМ-радио                           |

Тайлбар: Гамшгаас хамгаалах тусгай зориулалтын мэргэжлийн анги нь тухайн салбарын гамшгаас хамгаалах албанд харьяалагдах ба дайчлагдан ажиллах, гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах албаны даргын удирдлагад Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Мэргэжлийн ангийн дүрэм"-ийг мөрдөж ажиллана.